



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/264

Булган сум

Хойд бүсийн хоршоологчдын зөвлөгөөн зохион
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 166 дугаар “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хойд бүсийн малчид, хоршоологчдод мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
Гишүүд: Ч.Оюун-Эрдэнэчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн
хэлтсийн мэргэжилтэн)
Ч.Шүрэнцэцэг (Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Т.Жаргалант (Хоршоологчдын холбооны тэргүүн)
Сумын Засаг дарга нар
Сумын Засаг даргын Тамгын газрын Хөнгөн, жижиг, дунд
үйлдвэр, хоршоо ахуйн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбаасан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр,
худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга)

2. Дээрх сургалт, зөвлөгөөнийг бэлтгэл сайтай зохион байгуулж, малчид, хоршоологчдыг хамруулж ажиллахыг ажлын хэсэг (Д.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010373